

**ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРТ
ТУС БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЧДЫН ГАРГАСАН ГОМДЛЫН ДАГУУ
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд ажлын хэсэг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс Дуурь бүжгийн эрдмийн театр ажиллаж, ажилчдаас гаргасан гомдолд дурдагдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор шалгалтыг гүйцэтгэлээ.

Ажлын хэсэгт Салбарын хяналтын газрын дарга Ч.Энх-Амгалан ахалж, Хүний нөөцийн хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Б.Алтанцэцэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Д.Амарсанаа, мэргэжилтэн Э.Батхүлэг, Монголын ажилтан албан хаагчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Д.Өлзийсайхан, МҮЭ-ийн холбооны ерөнхий зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн, тэргүүлэгч гишүүн Д.Баттөгөлдөр нар ажиллалаа.

Батлагдсан удирдамжийн “Тав.Хяналт шалгалтын хамрах хүрээ, чиглэл” хэсэгт заасны дагуу ажилчдын гомдолд дурдсан дараах асуудлаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Шилэн дансны хөтлөлтийн журмын хэрэгжилт;
2. Нэмэлт орлогыг зарцуулах журмын хэрэгжилт;
3. Удирдлагын хамаарал бүхий этгээдэд хөрөнгө мөнгө зарцуулсан эсэх асуудлаар хувийн ашиг сонирхлын зөрчлийг шалгах;
4. Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг хууль тогтоомжийн хүрээнд батлуулсан эсэхийг шалгах;
5. Яамны дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах;
6. Албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн ажлын байрны дарамт үүсгэдэг эсэхийг шалгах;
7. Бусад асуудал.

**ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН
БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Нэг. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

1.1 “Шилэн дансны хөтлөх журмыг удаа дараа зөрчсөн” гэснийг шалгахад:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 06 дугаар 23 сарын 04-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу салбарын нийт байгууллагын 2025 оны эхний жилийн байдлаарх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд

дотоод аудитыг гүйцэтгэсэн. Энэхүү аудитаар тус байгууллага нь 2025 оны хагас жилийн байдлаар шилэн дансанд 22 нэр төрлийн мэдээллийг 87 талбарт мэдээлэхээс 2 удаа хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийн үнэн зөв, бодиттой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 28 алдаа гаргасан байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт гэсэн 2 талбарт хуулийн хугацаа хоцроосон.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 6 удаагийн 4,550.5 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй. Уг мэдээллийг гүйлээ хийснээс хойш 7 хоногийн дотор мэдээлэх хугацааг 8 удаа хоцроосон.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 удаагийн 310.3 сая төгрөгийг мэдээлээгүй, мөн 11 удаа хугацаа хоцроосон.
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг талбарт 86 удаагийн 328.9 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй, мөн түлш халаалт, гэрэл цахилгаан зэрэг тогтмол зардлыг сар бүрийн өссөн дүнгээр мэдээлэхгүй байна.
- Батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл талбарт бүтцийн задаргааг оруулаагүй 1-4 саруудад “оруулах мэдээлэл байхгүй” гэж мэдээлсэн.
- Тайлант хугацаанд байгууллагын дарга нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй холбоотой “Ашиг сонирхлын мэдэгдэл” гаргаж нийтэд мэдээлээгүй.
- Тайлант хугацаанд хөрөнгө, мөнгө захиран зарцуулсан 39 удаагийн 1,322.5 сая төгрөгийн мэдээлэхээс 29 удаагийн 516.1 сая төгрөгийн тушаал, гэрээг мэдээлээгүй байна. Мөн 3 тушаалыг мэдээлэхдээ хугацаа хоцроосон.

Дотоод аудитын дүнгээр тус байгууллагад Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт 67.8 хувьтай “Хангалтгүй” гэж дүгнэсэн.

Тус байгууллагаас дотоод аудитын шалгалтын мөрөөр илэрсэн алдааг залруулсан тухай тайланг ирүүлсэн. Таван сая төгрөгөөс дээш дүн бүхий орлогын гүйлгээг мэдээлээгүй 6 удаагийн 4,550.5 сая төгрөгийн санхүүжилтийн мэдээг нэгтгэн бөөн дүнгээр мэдээлсэн алдааг эс тооцвол дотоод аудитаар илэрсэн алдааг залруулсан гэж дүгнэв.

Хоёр. Байгууллагын нэмэлт үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, ашиглалтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт

2.1 “Байгууллагын нэмэлт үйл ажиллагааны орлогыг захиран зарцуулах журмыг удаа дараа зөрчсөн” гэснийг шалгахад:

Тус байгууллагын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 857.7 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд уг дүнг ССАЖЗЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газраас баталгаажуулсан байна.

Дотоод хяналт шалгалтын удирдамжийн хамрагдах хугацаа буюу 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 957.9 сая төгрөгийн орлого төвлөрч, Сангийн яамны Төрийн сангийн газарт зарцуулалтын эрхийн 8 удаагийн хүсэлт гаргаж 827.6 сая төгрөгийн эрх нээлгүүлэн, 756.7 сая төгрөгийг зарцуулж 201.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн үйл ажиллагааны 2025 оны орлогын бүрдүүлэлтийн тайлан
/мянган төгрөгөөр/

№	ДАНСНЫ АНГИЛАЛ	Мөнгөн дүн	Эзлэх хувь
1311	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	957,952.1	100
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагч олгосон дэмжлэг	2,000.0	0.21
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	913,152.1	95.32
131106	Түрээсийн үйл ажиллагааны орлого	28,700.0	3.0
131107	Уралдаан тэмцээний орлого	14,100.0	1.47

Үндсэн үйл ажиллагааны 957.9 сая төгрөгийн орлогын 95.3 хувийг үзвэр үйлчилгээний орлого, 3 хувийг тайзны болон цайны газрын түрээсийн орлого, 1.47 хувийг балетийн уралдаан тэмцээний хураамж, 0.2 хувийг ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын санхүүжилтийн орлогоор бүрдүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны 2025 оны орлогын зарцуулалтын тайлан
/мянган төгрөгөөр/

№	ДАНСНЫ АНГИЛАЛ	ЗАРЦУУЛАХ ЭРХ	ГҮЙЦЭТГЭЛ	ХУВЬ
II	НИЙТ ЗАРЛАГА	827,654.0	756,728.9	91.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	755,654.0	697,806.9	92.3
2104	Хангамж, бараа материалын зардал	53,318.6	42,801.3	80.3
210401	Бичиг хэрэг	10,031.8	8,665.1	86.4
210402	Тээвэр, шатахуун	6,000.0	4,000.0	66.7
210403	Шуудан, холбоо, интернэт	4,000.0	1,506.6	37.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон шавж устгах	2,160.0	1,566.0	72.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх зардал	31,126.8	27,063.6	86.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	130,272.1	126,826.3	97.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,994.6	26,834.5	92.5
210604	Урсгал засвар	101,277.5	99,991.8	98.7
2107	Томилолт, зочны зардал	23,250.0	5,293.0	22.8
210701	Гадаад албан томилолт	23,250.0	5,293.0	22.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	35,442.3	32,187.6	90.8
210801	Бусад нийтлэг АҮТХураамж	35,000.0	31,839.1	91.0
210802	Тээврийн хэрэгслийн татвар	442.3	348.5	78.8
80214	Уран бүтээл хийлгэх	513,371.0	490,698.7	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үй	513,371.0	490,698.7	

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,000.0	58,922.0	81.8
210801	Бусад нийтлэг АҮТХураамж	2,500.0	-	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	69,500.0	58,922.0	84.8

Тайлант хугацаанд нэмэлт үйл ажиллагааны орлогоос цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардалд хөрөнгө төсөвлөж зарцуулаагүй, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 69.5 сая төгрөгийн эрх нээлгүүлэн, 58.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зарцуулалтын тайлангаас дараах зардлуудыг сонгон авч зардлын гүйцэтгэлийн нөхцөлд байдалд дүн шинжилгээ хийв. Үүнд:

Эд хогшил, урсгал засварын зардал:

Эд хогшил, урсгал засварын зардлын бүлэгт 130.3 сая төгрөгийн зарцуулалтын эрх нээлгүүлэн 126.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнийг тодруулбал багаж техник хэрэгсэл худалдан авахад 26.8 сая төгрөг, урсгал засварын зардалд 100.0 сая төгрөг зарцуулжээ.

Урсгал засварын ажил гүйцэтгэх тухай 86.9 сая төгрөгийн 8 гэрээг 6 иргэн, 2 компанитай, засварын ажилд шаардлагатай бараа материал худалдан авахад 7 удаагийн 13.2 сая төгрөгийн гүйлгээг нэр бүхий 7 компанитай хийж материал бэлтгэсэн байна.

Урсгал засварын ажил гүйцэтгэсэн иргэн, ААН-ийн мэдээлэл

№	Гүйцэтгэгч иргэн, ААН-ийн нэр	Гэрээний дугаар огноо	мөнгөн дүн	Гүйцэтгэсэн ажил	Зураг төсөв	Гэрээ дүгнэсэн акт	Илэрсэн алдаа
1	Т.Мөнхцэцэг	25.02.01 №0	17,600.0	Душны өрөөний засвар	байхгүй	Тийм /огноо дугаар байхгүй/	Засварын зураг төсөвгүй, урьдчилгаа санхүүжилтийн гэрээнд зааснаас илүү олгосон
2	Н.Ариунжаргал	25.02.01 №0	14,250.0	Цэвэр бохир усны сангийн засвар	байхгүй	Тийм /огноо дугаар байхгүй/	Засварын ажлын зураг төсөвгүй
3	Хос гоо баяр интернейшнл ХХК	25.04.01 №0	19,502.7	1, 2, 3-р давхрын коридорын 251 мкв хана бүрж шинэчлэх	байхгүй	Тийм	Засварын ажлын зураг төсөвгүй
4	А.Мөнхзаяа	25.04.11 №0	19,300.0	Гоёлын хавтан залгаа, сликон цавуу	байхгүй	Тийм	Бараа материал бүртгээгүй шууд зарлагдсан
5	Б.Мягмар	25.05.02 №10	6,150.0	1 давхрын үүдний плита солих ажлын хөлс	байхгүй	Тийм №10	Засварын ажлын зураг төсөвгүй

6	Ж.Ренчиннам жил	25.04.15 №0	3,150.0	Хаалганы автомат нугас солих, засвар үйлчилгээни й хөлс	байхгүй	Үгүй	150.0 мянган төгрөгийн татуурга солих ажлын хөлс 3.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан
7	Буянт оюу	Гэрээгүй	5,489.5	автомашин засвар үйлчилгээ	Техник ийн оношилг оо хийсэн акт	Үгүй	Сэлбэгийг бараа материал бүртгээгүй шууд зарлагдсан
8	Г.Дайриймаа	25.06.03 №0	1,500.0	Засвар үйлчилгээ хийх, зөвлөгөө өгөх ажлын төлбөр	байхгүй	Тийм 25.07.01	-
	Нийт дүн		86,542.2				

Ажилчдын халуун усны өрөө, цэвэр бохир усны сангийн засвар, коридорын хана бүрэх, шалны плита солих зэрэг урсгал засварын ажлын төсвийг 5 хувааж тендер шалгаруулалтын босго үнээс доош дүнгээр гэрээ байгуулан 4 иргэн, 1 компанитай 76.8 сая төгрөгийн гэрээ байгуулан ажил үүрэг гүйцэтгүүлснийг шалгахад засварын ажлын зураг, төсөв байхгүй, засварт шаардлагатай бараа материалыг нэг этгээдээс худалдан авах, засварын ажлыг өөр этгээдээр гүйцэтгүүлэх байдлаар тендер шалгаруулалтын босго үнээс доош дүнгээр шууд гэрээ байгуулсан, гэрээг байгууллагын өмч хамгаалах комиссоор оруулж гэрээг дүгнүүлээгүй, дотоод хяналтгүйгээр гэрээ дүгнэсэн нэг хуудас акт үйлдсэн зөрчил илэрч байна.

Мөн урсгал засварын ажил гүйцэтгэхэд шаардлагатай 20.3 сая төгрөгийн бараа материалыг НББ-ийн дансанд орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 *нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт* гэснийг зөрчсөн байна.

Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчим”-ын 6 дугаар зүйлийн 6.4.4¹-т заасан зарчмыг мөрдөөгүй, мөн тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4²-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа гаргасан байна.

Уран бүтээл хийлгэх бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал:

Тайлант хугацаанд уран бүтээл хийлгэх зардалд 513.4 сая төгрөгийн зарцуулалтын эрх нээлгүүлэн 490.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

¹ 6.4.4.хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох

² 24.4.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.

Уран бүтээл хийх зориулалтаар зарцуулсан зардлын ангилал

д/д	Зардлын ангилал	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Эзлэх хувь
1	Улан-Үдэ хотод ажилласан албан томилолтын зардал	97,107.6	19.8
2	ОХУ, БНСУ-ын уран бүтээлчдийн зочид буудлын төлбөр	90,523.5	18.4
3	Хэвлэл, зар сурталчилгаа	54,859.2	11.2
4	Номадик балет, Прокурорын ойн тоглолтод оролцсон жүжигчдийн хөлс, урамшуулал	49,000.0	10.0
5	Гэрээний төлбөр	34,379.0	7.0
6	ОХУ, БНСУ-ын уран бүтээлчдийн хоол, Хунт нуур 50 жилийн ойн арга хэмжээний хүндэтгэлийн хүлээн авалтын зардал	32,953.4	6.7
7	Автобус унаа, тээврийн зардал	30,300.0	6.2
8	Балетын шүүгчид, Хунт нуурт тоглосон жүжигчний онгоцны тийз тасалбарын үнэ	25,793.7	5.3
9	Зөвлөх үйлчилгээ, сургалтын төлбөр	17,563.0	3.6
10	Тоглолтын уран бүтээлч, зочин шүүгчид өгсөн бэлэг дурсгал, цэцэг	16,747.0	3.4
11	Тоглолтын хувцас хэрэглэл, засвар үйлчилгээний зардал	13,004.5	2.7
12	Тоглолтын хөгжим, эд хэрэгслийн түрээсийн зардал	10,885.0	2.2
13	Тэмцээний шагнал урамшуулал, медаль, өргөмжлөл хийлгэх зардал	8,886.0	1.8
14	Уралдаан тэмцээн, хүндэт зочдын ундаа ус цай кофе авсан зардал	8,697.0	1.8
	Нийт дүн	490,698.8	

Тайлант хугацаанд Дуурь бүжгийн эрдмийн театрын Уран сайхны зөвлөлөөс шинэ уран бүтээл, шинээр сэргээн тавьсан дуурь, балетын бүтээлийг хийгээгүй, ОХУ-ын Буриадын театр, БНСУ-ын уран бүтээлчдийг оролцуулсан “Хунт нуур” балетын 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, ОХУ-ын Улан-Үдэ хотод Аиди дуурь болон Гала тоглолт хийхтэй холбоотой арга хэмжээнд уран бүтээлийн зардлын дийлэнхийг зарцуулсан байна.

Номадик балет, Прокурорын ойн тоглолтод оролцсон жүжигчдийн тоглолтын хөлс, урамшуулалд нийтдээ 19.0 сая төгрөгийг олгосон байна. Үүнээс Прокурорын байгууллагын ойн арга хэмжээнд оролцсон уран бүтээлчдийн тоглолтын төлбөрт 11.5 сая төгрөгийн гэрээ байгуулан, төлбөрийг бүрэн авч нэр бүхий 11 жүжигчин, 3 удирдах албан тушаалтанд 6.0 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Тоглолтын урамшуулал хэлбэрээр бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамж, ажил үйлчилгээний зардлын ангиллаас уран бүтээлчдэд 19.0 сая төгрөг олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.1, 25.1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Балетын уралдаан тэмцээн, гадаадын уран бүтээлчид, шүүгчдэд зориулан 16,747.0 мянган төгрөгийн бэлэг дурсгал, цэцэг худалдан авах зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглосон заалтыг зөрчсөн байна.

Байгууллагын 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар ажиллагсадтай холбоотой 311.0 мянган төгрөгийн, хувь хүн, байгууллагад төлөх 24,490.0 мянган төгрөгийн нийт 24,800.1 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

Үүнээс дүгнэхэд Дуурь бүжгийн эрдмийн театрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”*-ын 5.1-д заасан төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараах эрэмбийг баримтлан зарцуулах тухай заалтын 5.1.1-д заасан “эх үүсвэр дутагдаж байгаа, эсхүл өр төлбөр үүссэн үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал:

Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 69.5 сая төгрөгийн зарцуулалтын эрх нээлгүүлж 58.9 сая төгрөгийг, харин уран бүтээл туурвих зардлын ангиллын төсвөөс 30.0 сая төгрөгийг урамшуулалд зарцуулсан байна. Үүнд:

- Цагаан сарын баярын үеэр байгууллагын ахмад ажилтан 180 хүнд нэг бүр нь 149.0 мянган төгрөгийн үнэ бүхий бэлэг гардуулахад иргэн Б.Анужинтай 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 26,820.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авах гэрээ байгуулан нэг удаагийн тэтгэмжийн зардлаас зарцуулсан байна. Бэлэг тараасан жагсаалтад 177 ахмадын нэрс орсноос 157 ахмад бэлэг хүлээн авсан гарын үсэг зурсан, ахмадад өгсөн бэлгийг нягтлан бодох бүртгэлийн бараа материалын дансанд орлого, зарлагаар бүртгээгүй, тараагдаагүй үлдсэн тоос сорогчийн бүртгэл тооцоонд дотоод хяналт хангалтгүй тавигдаж байна.
- Захирлын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн Б/235 дугаар тушаалаар Хөгжим ангийн гоцлол хөгжимчин М.Сэргэлэнбатын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 30.0 сая төгрөгийг орон сууцны урьдчилгааны буцалтгүй тусламж олгосон байна.
- Захирлын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн Б/236 дугаар тушаалаар Гоцлол дууны ангийн гоцлол дуучин Б.Гомбо-Очирын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 30.0 сая төгрөгийг буцалтгүй тусламж олгосон байна.

Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”*-ын 5.1.2 “байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг нь харгалзан урамшуулах”, 5.1.3 “нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх” гэсэн заалтын зориулалтаар зарцуулах хөрөнгийн нийт хэмжээ үндсэн үйл ажиллагааны орлогын нийт дүнгийн 60 хувиас хэтрэхгүй байна гэж тогтоосон байна.

Дээрх шаардлагыг хангасан эсэхийг нягтлахад үндсэн үйл ажиллагааны орлогын зарцуулалтын эрх нээлгэсэн дүнгийн 12.02 хувь буюу 99.5 сая төгрөгийг эдгээр нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд төсөвлөж 88.9 сая төгрөгийг зарцуулсан нь хууль тогтоомжид заасан хувьд хүрээгүй байна гэж дүгнэв.

Гурав. Удирдлагын нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах хууль тогтоомжийн хэрэгжилт

3.1 Хамаарал бүхий этгээдэд мөнгөн шилжүүлэг хийсэн нь тогтоогдсон гэснийг шалгахад:

Гомдол гаргасан ДБЭТ-ын ажилчдын төлөөлөлтэй уулзахад удирдлагын өөрийн хамаарал бүхий этгээдэд мөнгө шилжүүлсэн баримтыг ажлын хэсэгт өгсөн. Энэхүү баримтад үндэслэн хяналт шалгалтыг хийлээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн сангаас лавлахад Улаанбаатар балет ХХК /РД6231039/ -ны хувьцаа эзэмшигчээр иргэн Дугараа овогтой Алтанхундага бүртгэлтэй ба компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалд ажилладаг, эцсийн өмчлөгчөөр бүртгэлтэй байна.

Тус байгууллагын 2024 оны төсвийн зарцуулалтын ерөнхий журналд Улаанбаатар балет ХХК-тай харилцсан 2 удаагийн ажил гүйлгээ хийгдсэн ба эхний гүйлгээг театрын өмнөх захирал Б.Сарантуяа хийсэн, 2 дахь гүйлгээ нь Д.Алтанхуяг захирлын ажил хүлээн авснаас хойших хугацаанд хийгдсэн байна.

№	Гүйцэтгэгч	Гэрээний дугаар огноо	мөнгөн дүн	Гүйлгээний утга	Төлбөр төлсөн	
					мөнгөн дүн	огноо
1	Улаанбаатар балет ХХК	гэрээгүй	1,381.5	Тоглолтын нүүр будгийн материалын үнэ	1,381.5	24.03.13-ны өдөр
2	Улаанбаатар балет ХХК	24.12.09 №0	18,618.5	Нүүр будгийн бараа материал нийлүүлэх	18,618.5	24.12.27-ны өдөр
	Дүн				20,000.0	

Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуяг өөрийн хамаарал бүхий этгээдтэй 18,618.5 мянган төгрөгийн гэрээ байгуулж, төлбөрийг шилжүүлсэн үйлдэл гаргасан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1³ - д заасныг зөрчсөн тул Авлигатай тэмцэх газрын 2025 оны 03/7789 дүгээр албан бичгээр түүнд сахилгын арга хэмжээ тооцуулах шийдвэр ирүүлж Сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар сахилгын арга хэмжээ тооцсон байна.

Д.Алтанхуягийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын 2024 оны мэдүүлэгт дээр дурдсан хамаарал бүхий хувь хүн, хуулийн этгээд бүртгэгдсэн байна.

Дөрөв. Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг хууль тогтоомжийн хүрээнд батлуулсан эсэхийг шалгах;

4.1 Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын эсрэг данхар бүтэц хийсэн тухай асуудлыг шалгахад.

Дуурь, бүжгийн эрдмийн театр нь батлагдсан нийт **285** /удирдах 9, гүйцэтгэх 257, туслах 19 албан тушаал/ орон тоотой. Өнөөдрийн байдлаар **275** /удирдах 7, гүйцэтгэх 251, туслах 17/ албан хаагч ажиллаж байна. Үүнээс:

- Жинхлэн томилогдсон 237 албан хаагч;

³ 11.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- Туршилтын хугацаагаар ажиллаж байгаа 15 албан хаагч;
- Гэрээгээр ажиллаж байгаа 13 албан хаагч;
- Сул орон тоо-10 байна.

2025 оны 01 дүгээр сараас 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд нийт хүний нөөцтэй холбоотой **378** Б тушаал батлагдсан байна. Үүнд:

- Шинээр ажилд томилсон 45;
- Гэрээгээр ажиллуулах тухай 25;
- Албан тушаалд шилжүүлэн томилсон 4;
- Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай 4;
- Ажлаас чөлөөлсөн /ажил олгогчийн санаачилгаар 7, өөрийн хүсэлтээр 21, гэрээний хугацаа сунгаагүй 4/ 32;
- Сахилгын шийтгэл ногдуулсан 10;
- Чөлөө олгох тухай 113;
- Ээлжийн амралт олгох тухай -18;
- Буцалтгүй тусламж олгох тухай -24;
- Бусад 103 /гэрээ болон туршилтын хугацаагаар ажиллаж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай 62, гэрээ цуцалсан -15, үндсэн ажилтнаар томилох тухай 26/ тушаал байна.

4.2 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/200 дугаар тушаалаар Дуурь, бүжгийн эрдмийн театрын дүрэм, бүтцийг шинэчлэн баталсан байна. Шинэ бүтцийн дагуу Дуурь, бүжгийн эрдмийн театрын захирлын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар бүтэц орон тооны жагсаалтыг баталсан. “Дуурь, бүжгийн эрдмийн театрын Ажлын байрны нэр, ангилал зэрэглэл, орон тоог шинэчлэн батлах тухай” гэж тушаалыг боловсруулж батлах ёстой байсан. Мөн тушаалд ажлын байрны орон тоог нэгдүгээр хавсралтаар баталж гэсэн – өөр хавсралтгүй тушаал тул томъёолол буруу. Мөн тушаалын 3-т тушаалыг нийт албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг албан тушаалын чиг үүргийн биш Уран сайхны удирдаачид үүрэг болгосон байна.

Дуурь, бүжгийн эрдмийн театрын бүтэц, орон тооны харьцуулалт

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 121 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тоо			Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/200 дугаар тушаалаар баталсан /шинэ/ бүтэц орон тоо			Зөрүү
Нэгж	Алба	Орон тоо	Нэгж	Алба	Орон тоо	
Захиргаа - үзвэр үйлчилгээний хэлтэс	Захиргаа, удирдлага	4		Удирдлага, захиргаа	7	+3
	Хүний нөөцийн алба	4	Үйл ажиллагааны хэлтэс	Хүний нөөцийн алба	3	-1
	Санхүүгийн алба	5		Санхүүгийн алба	6	+1
	Үйлчилгээний алба	27		Үйлчилгээ, аж ахуйн алба	29	+2

	Маркетингийн алба	6	Стратеги, төлөвлөлтийн хэлтэс	Маркетинг, хамтын ажиллагааны алба		5	-1
				Сургалт, мэдээллийн алба		2	+2
		Захиргааны орон тоо	46		Захиргааны орон тоо 52		
Уран бүтээлийн хэлтэс	Уран бүтээлийн гүйцэтгэх алба	32	Уран бүтээлийн хэлтэс	Уран сайхны удирдагч		1	-31
	Хөгжмийн алба	51		Хөгжмийн хүрээлэн		55	+4
	Балетын алба	46		Балетын театр		56	+10
	Гоцлол дууны алба	28		Дуурийн театр	Гоцлол дуу анги	32	+4
	Найрал дууны алба	50			Найрал дуу анги	52	+2
	Тайзны алба	32		Тайз, технологи		34	+2
Уран бүтээлийн хэлтсийн нийт орон тоо		239	Урын сан / шинэ бүтцээр уран бүтээлийн гүйцэтгэх албанаас тусад нь гаргасан/		3	3	
					233	-6	
Нийт орон тоо		285		Нийт орон тоо		285	

Өмнөх бүтцээс 285 орон тооноос шинэ бүтцээр +13 орон тоо нэмсэн /Уран бүтээлийн хэлтэст +7, /Захиргаанд +3, Үйлчилгээ аж ахуй албанд +2, санхүүгийн +1/, хасагдсан орон тоо 13 /Уран бүтээлийн хэлтсээс -13/ байна.

Шинэчлэгдсэн бүтцээр шинээр нэмэгдсэн орон тоо:

Захиргаанд: 1.Захиргаа, хэрэгжилтийн дарга +1

2.Үйл ажиллагааны хэлтсийн дарга +1

3.Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга +1

Санхүүгийн албанд: 1.Тооцооны нягтлан бодогч +1

Аж ахуй албанд: 1.Цахилгаанчин +1,

2.Мужаан +1, нийт 2 орон тоо нэмэгдсэн . Бүгд нийт 6

Уран бүтээлийн гүйцэтгэх албанд шинээр нэмэгдсэн

1.Дуурийн театрын продюсер +1

2.Хөгжмийн хүрээлэнгийн продюсер +1

3.Балетын театрын продюсер +1

4.Балетын бүжигчин +2

5.Балетын гоцлол бүжигчин +2 **нийт 7 орон тоо нэмэгдсэн.**

Уран бүтээлийн гүйцэтгэх албанаас хасагдсан орон тоо:

1. Удирдаач -1

2. Багш /Балетын/ -2

3. Багш /Дуурь/ -1

4. Туслах балетмейстр -1

5. Туслах балетмейстр -1

6. Уран бүтээлийн гүйцэтгэх албаны дарга -1

7.Концертмейстр -2

8. Гоцлол дуучин -2

9. Хөгжим засварчин /хөглөгч/ -1

10. Найрал хөгжмийн инпекстор -1 **Нийт 13 орон тоо**

хасагдсан

Байгууллагын бүтцийг шинэчлэн боловсруулах асуудлаар Захирлын зөвлөл болон Уран сайхны зөвлөлийн хурлаар нийт 3 удаа /2025.02.12, 2025.02.19, 2025.05.05/ хэлэлцэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9-д заасны дагуу байгууллагын бүтэц, дүрмийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоосон байна.

Шинэ бүтцийн дагуу ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулж баталгаажуулах, орон тоонд багтаан хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулахыг Хүний нөөцийн албаны даргад даалгасан боловч хэрэгжилт хангагдаагүй.

Тав. Яамны дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

5.1 Яамны дотод аудитаас тогтоосон зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүйг гэснийг шалгахад:

Авлигатай тэмцэх газрын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 05/5480 дугаар албан бичгийн дагуу ДБЭТ-ын удирдлагатай холбоотой асуудлаар яамны ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс тус байгууллагад сайдын баталсан удирдамжийн хүрээнд ажиллаж, дотоод хяналт шалгалтын тайлангаар 4 зөвлөмжийг хүргүүлснийг энэхүү шалгалтын явцад хянаж үнэлэв. Тус байгууллагаас зөвлөмжийн биелэлтийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдөр яамны ХШУДАГ-т ирүүлсэн болно.

Зөвлөмжийн хэрэгжилтийн дүн:

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжилтэд хийсэн үнэлгээ	Хувь
1	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжүүлж ажиллах;	Тайлант хугацаанд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер зарлаж худалдан авалт хийгээгүй байна.	0%
2	Шилэн дансны тухай хуулийн дагуу захирлын баталсан тушаалыг бүрэн мэдээлэх, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг тухай бүр буюу гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор мэдээлж байх;	Яамны ХШУДАГ-аас гүйцэтгэсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн дотоод аудитын тайлангаар хангалтгүй үнэлгээ авсан	80.0
3	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан журмыг хатуу мөрдөн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй, санхүүгийн тайланд тусгахгүй байхад анхаарч ажиллах;	Урсгал засварын ажил гүйцэтгэхэд шаардлагатай 38.0 сая төгрөгийн бараа материалыг 1 иргэн, 8 ААН-ээс худалдан авч НББ-д бүртгэсэн эсэхийг хянахад 1 иргэнээс авсан 19.3 сая төгрөгийн бараа материалыг дансанд орлогоор бүртгээгүй байна.	88.9%
4	Түрээсийн бартерийн орлогыг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн бүртгэж, санхүүгийн тайланд тухай бүр бүрэн тусгаж, тайлагнах;	Тайлант хугацаанд цайны газрын түрээсийн гэрээний дагуу 9.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. МАК группын ойн баяр наадмын тоглолтод уран бүтээлчдийг оролцуулан 80.0 сая төгрөгийн бартерын гэрээ байгуулсан боловч санхүү, нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.	50%
	Нэгдсэн үнэлгээ		54.7%

Зөвлөмжийн биелэлтийн тайлан, хэрэгжүүлсэн ажлын үр дүнг газар дээр шалгаад өмнөх шалгалтын зөвлөмжийн биелэлтийг 54.7 хувьтай, хангалтгүй гэж дүгнэв. Энэ нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 10.2 Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагчийн акт, албан шаардлага, гаргасан үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг шалгалтад хамрагдсан байгууллагын удирдлага, албан хаагчид хэрэгжүүлэх үүрэгтэй гэснийг зөрчсөн байна.

Зургаа. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох журмын хэрэгжилт.

6.1 Байгууллагын удирдлагаас албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн ажлын байрны дарамт үүсгэдэг эсэхийг шалгахад;

Тус байгууллагын Ёс зүйн дэд хороонд ирүүлсэн өргөдөл, гомдол болон бусад мэдээлэлтэй танилцаж, нийт албан хаагчдаас удирдлагын манлайлал, ажлын байрны дарамтын талаар судалгааг авч ажилласан. Тус театрт шалгалтаар ажиллах хугацаанд дараах зөрчил ажиглагдсан. Үүнд:

- Удирдлагатай холбоотой өргөдөл, гомдлыг харьяалах дээд шатны байгууллагын Ёс зүйн дэд хороонд хандаж гаргаагүй, үйлдвэрчний эвлэлийн хороонд хандсан.
- Дуурь бүжгийн эрдмийн театрын Ёс зүйн хороо “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” болон дагаж гарсан дүрэм журмын дагуу нийт хамт олны хурлыг зохион байгуулаагүй анги нэгж тус бүрдээ зохион байгуулан гишүүдийг сонгосон байна. Энэ нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт “Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр таван жилийн хугацаагаар сонгоно” гэснийг зөрчсөн байна.
- Ёс зүйн дэд хороо нь дэд хорооны ажиллах журмын “5.13 Дэд хороо нь тухайн байгууллага доторх газар, хэлтэс, нэгж буюу албан тушаалтан, албан хаагчид хандсан зөвлөмж өгөх болон бусад байгууллагын албан тушаалтан, албан хаагч, иргэнд мэдээ, мэдээлэл, нотлох баримтыг гаргуулахаар хандахдаа байгууллагынхаа албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг ашиглана.” гэж заасны дагуу хэвлэмэл хуудас, тэмдэг ашиглан баримт бичгээ баталгаажуулж хэвших шаардлагатай байна.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1 дэх хэсэгт “гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах” гэж заасны дагуу тус хорооны гишүүдэд 2025 онд урамшуулал олгогдоогүй байна.

Иймд Ёс зүйн дэд хороог хуульд нийцүүлэн шинэчлэн байгуулах шаардлагатай байна.

Ажлын байрны дарамт учруулсан гэх гомдлын хүрээнд: Ёс зүйн дэд хорооны дарга М.Даваадорж 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр шалгалтын ажлын хэсгийн гишүүдэд “...Д.Алтанхуяг захирал нэг хурлын дараа Чамтай өөрөөр ярина гэж татаж байгаад хэлсэн...” гэх асуудлын хүрээнд Д.Алтанхуягаас тодруулга авахад тийм үйлдэл гаргаагүй гэж мэдүүлсэн. Харин М.Даваадоржийг баримтаар нотлохыг хүсэхэд боломжгүй гэсэн хариултыг өгсөн. Иймд М.Даваадоржийг захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуяг дарамталсан гэх асуудал баримтаар нотлогдохгүй байна.

Долоо. Бусад асуудал.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн дотоод журам, Хамтын гэрээ, санхүү зэрэг асуудлуудын хүрээнд тодорхой зөрчлүүдийг илрүүлсэн бөгөөд дараах байдлаар нийтлэг зөрчил илэрсэн болно. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй
- Галын аюулгүй байдлыг хангаагүй
- Хамтын гэрээний хэрэгжилт хангалтгүй
- Санхүүтэй холбоотой зөрчлүүд /хамаарал бүхий байгууллага, уран бүтээлчдийн мөнгийг олгоогүй зэрэг/
- Монгол улсын Сангийн сайдын тушаал 2022 оны 282 тоот журмын “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-г зөрчсөн. Журам байхгүй төсвөөс давсан нэмэлт орлогыг өөрийн дураар захиран зарцуулдаг.

Мөн Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн **A/166, A/63, A/73** Шалгуур үзүүлэлт батлах тухай тушаалыг зөрчсөн.

- Нэмэлт орлогыг болон “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг ялгаварлан гадуурхаж дур мэдэн ялгаатай олгодог.

ДҮГНЭЛТ

Ажлын хэсгээс удирдамжид заасны дагуу ДБЭТ-ын ажилчдын гомдолд дурдсан асуудлуудыг судлан байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын зарцуулалтын гүйцэтгэл, нэг удаагийн тэтгэмж олгосон зардлын зарцуулалт, Шилэн дансны хөтлөлт, бүтэц орон тоо, зохион байгуулалт, удирдлагын хувийн ашиг сонирхол, ёс зүйн асуудлын талаар холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитаар тус байгууллагын шилэн дансны хөтлөлтийг 67.8 хувьтай, хангалтгүй гэж дүгнэсэн бөгөөд аудитаар илэрсэн алдаа, дутагдлыг арилгаж 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр биелэлтийг ирүүлснийг дахин хянаж үзэхэд хэрэгжилт сайжирсан дүнтэй байна.
2. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын зарцуулалтыг Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан зардлын эрэмбийг баримтлан зарцуулаагүй, санхүүгийн байдлын 2025 оны хагас жилийн тайлангаар 24.8 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, урсгал засварын зардалд зураг төсөвгүй ажлыг тендер сонгон шалгаруулалтгүйгээр 4 иргэн, 1 ААН-тэй 76.8 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан, дотоод хяналтгүйгээр зарцуулсан, үйл ажиллагааны эрх нээлгүүлсэн орлогын 13 хувийг буюу 107.9 сая төгрөгийг цалин урамшуулал, тэтгэмжийн зардалд зарцуулсан нь холбогдох

хууль тогтоомжид заасан урамшуулал, буцалтгүй тусламжид зарцуулах дээд хувь хэмжээний шаардлагыг бүрэн хангахгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 24 дүгээр зүйлийн 24.4, 46 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 10.3, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”*-ын 5.1-д заасан заалтыг тус тус зөрчсөн.

3. Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуяг нь өөрийн хамаарал бүхий этгээдийн эзэмшлийн Улаанбаатар балет ХХК-тай гэрээ байгуулан, 18.6 сая төгрөгийг шилжүүлж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1⁴ - дэх заалтыг зөрчсөн тул ССАЖЗ-ын Сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар сахилгын арга хэмжээ тооцож хариуцлага хүлээлгэсэн.
4. Яамны ХШҮДАГ-аас 2025 оны 04 дүгээр сард гүйцэтгэсэн дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 54.7 хувьтай, хангалтгүй байгаа нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 10.2 дахь заалтыг зөрчсөн гэж дүгнэв.
5. Тус байгууллагад 2025 оны эхний 9 сарын байдлаар ажлаас чөлөөлсөн 32, ажилд шинээр авсан 45 тушаал гарснаас дүгнэхэд хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн ихтэй, ялангуяа байгууллагын захиргааны ажилчид тогтвор суурьшилгүй, өмнөх бүтэц зохион байгуулалттай харьцуулахад захиргааны албадыг удирдах хэлтсийн даргын 3 орон тоог бий болгон удирдлагын шат дамжлагыг нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.9 дэх заалтын ... чиг үүргийн давхардлыг арилгах... гэсэн эрх, үүргийг хангаж ажлаагүй байна.
6. Байгууллагын ёс зүйн зөвлөлийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.2 дахь заалтын дагуу нийт албан хаагчдын олонхын саналаар байгуулаагүй, удирдлагаас ажлын байрны дарамт үзүүлсэн тухай асуудал баримтаар нотлогдохгүй байна.
7. Ажилчдад ажлын байрны дарамт үзүүлдэг, ажлын үр дүнг зөв тооцдоггүй, ҮЭ-ийн хорооноос санал авдаггүй, хавсран ажилласан үеийн нэмэгдэл олгодоггүй, ялгаварлан гадуурхдаг, давсан нэмэлт орлогыг шударга бус хуваарилдаг, ажилчдын хөдөлмөрийн нөхцөл аюултай байгаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хуулиудыг зөрчсөн гэж Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөллөөс дүгнэв.

⁴ 11.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. Илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанхуягт Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага тооцох, Дуурь бүжгийн эрдмийн театрын захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтыг хийж, удирдлагыг томилох.
2. Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг ССАЖЗ-ын Сайдын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 01/2515 дугаар албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүрэгт мандатын шинжилгээ хийж, удирдах, гүйцэтгэх, туслах, албан тушаалын зохистой харьцааг тодорхойлж, батлагдсан төсөвт багтаан байгууллагын орон тооны хязгаарыг бүтэц, дүрмийн дагуу шинэчлэн батлуулах.
3. Театрын захиргаа удирдлага, санхүүгийн алба нь байгууллагын мэдээллийн ил тод байдал, үнэн зөв байдлыг хангаж ажиллах, аливаа шийдвэрийг хамт олны саналыг үндэслэн шийдвэрлэж байх, төсөв санхүүгийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд тавих дотоод хяналтад ажил хариуцсан нэгж, албан хаагчийн хүлээсэн чиг үүргийн дагуу оролцуулж дотоод хяналтыг сайжруулах, ажилтныг гаргасан санал санаачилга, үзэл бодлоос хамааруулан ялгаварлан гадуурхахгүй байхад анхаарч ажиллах.
4. Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан *“Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”*-ын 5.1-д заасны дагуу төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн үйл ажиллагааны орлогыг үүссэн өр төлбөрийг барагдуулах, ажилчдын цалин урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх гэсэн эрэмбийг баримтлан зарцуулах.
5. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу байгууллагын ёс зүйн зөвлөлийг байгуулах.
6. Дотоод хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэн хариуг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор яамны ХШҮДАГ-т ирүүлэх.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ